



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Харлан сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdlg@domod.gov.mn
Цахим хуудас: Domod.gov.mn

2024.03.14 № 1/527
танай 2024.04.30 ны № 2/16 -Т

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАСАГЛАЛЫГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗОХИЦУУЛАГЧ Ш.ЦОЛМОН ТАНАА

Аймгийн Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод
Байдлын Санаачилга /ОУИТБС/-ын 2023 оны Дэд
зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,
2024 оны Дэд зөвлөлийн үйл ажиллагааны
төлөвлөгөөг Танд хүргүүлж байна.

Хавсралт: хуудастай



212407040



ДОРНОД АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023.03.06

Зорилтууд	Төлөвлөсөн ажлууд	Үр дүн	Биелэлт	Хувь
1. Орон нутаг дахь тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг хангах	1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүр албан ёсны цахим хуудсаар дамжуулан авч байх;	Баталгаат мэдээллээр хангагдана.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүр Ашигт малтмал газрын тосны газрын mgram.gov.mn сайтаар дамжуулан авч ажиллаж байна.	100
	2.Аймгийн уул уурхайн цахим хаягт аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн байршуулах;	Аж ахуйн нэгж тус бүрийн мэдээлэл нээлттэй байршсан байна.	Аймгийн уул уурхайн цахим хаяг болох mining.dornod.gov.mn сайтад Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтад заасны дагуу гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн танилцуулга байршсан байна.	100
2. Орон нутаг, тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын харилцааг сайжруулах, байгаль орчныг хамгаалахаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	3.Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон орон нутагт худалдаа үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтарсан уулзалтыг зохион байгуулах;	Орон нутаг, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагаа, харилцаа сайжирна.	Эрдэс баялгийн салбарын ашиг тус, үр нөлөөлөл, ил тод байдлыг оролцогч талуудад зөвөөр хүргэх, хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн тэслүүдийг олон нийтэд таниулах замаар оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Зүүн бүсийн "Хариуцлагатай уул уурхай" 2023 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Өдөрлөгт Эрдэс баялгийн салбарын ашиг тус, үр нөлөөлөл, ил тод байдлыг оролцогч талуудад зөвөөр хүргэх, хариуцлагатай уул уурхайн тэслүүдийг олон нийтэд таниулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилготой тус чуулганд Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн ЗДТГ, төрийн захиргаа, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн	100

			иргэд болон тус бүсэд ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд тэргүүтэй 200 гаруй төлөөлөл оролцов.	
	4.Салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдөн ажиллаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан үйл ажиллагааг дэмжих;	Олон нийт хариуцлагатай уул уурхайн талаар мэдээлэлтэй болсон байна.	Салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдөн ажиллаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчилан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.	100
	5.Ашигт малтмалын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг дүгнэн хэлэлцүүлж, олон нийтэд сурталчилах;	Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх дэмжлэг тодорхой болж, гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгдсэн байна.	Тайлант онд "Байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ" байгуулсан 18 аж ахуйн нэгжүүдийн гэрээг дүгнэх ажиллагааг зохион байгуулаад байна.	100
	6. www.iltodgeree.mn -д бүх сумдын байгуулсан гэрээ орсон эсэхийг шалгах, нөхөн оруулах;	Цахим сайтад гэрээ бүрэн байршсан байна.	"Байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-нүүд iltodgeree.mn сайтад гэрээнүүд байршсан болно.	100
3. Дэд зөвлөлийн гишүүдийн мэдлэг, мэдээлэл солилцох боломжийг бий болгох, үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх	7.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөгөөн, цуврал сургалтуудад идэвхитэй хамрагдах;	Дэд зөвлөлийн гишүүд, уул уурхайн салбарын, мэдээ мэдээллээр хангагдсан байна.	Уул уурхай бүхий сумдад сумын Засаг даргаар ахлуулсан дэд зөвлөлийн ажлын хэсгийг чадавхжуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	90
	8.Дэд зөвлөл байгуулагдаагүй сумдуудад тухайн сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан дэд зөвлөлийг байгуулах;	Бүх сумдад дэд зөвлөл байгуулагдсан байна.	Дорнод аймгийн 14 сумдаас 12 суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 18 аж ахуйн нэгж "Байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг	100

			хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"- байгуулсан бөгөөд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан дэд зөвлөлийг байгуулсан.	
9.Аймгийн 2023 оны ОУИТБС-ын тайланг сумдаас холбогдох мэдээллийг хүлээн авч, нэгтгэн цахимаар гаргах;	Тайлан бүрэн гарсан байна.	мэдээ гарсан	Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 263 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн 3-р маягын дагуу мэдээллийг хүлээн авч цахимд байршуулсан.	100
10.Хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь ажиллах;	Хуулийн зөрчил буурсан байна.	зөрчил буурсан байна.	Хамтын ажиллагааны гэрээг дүгнэх ажлын хүрээнд хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж ажилласан.	90
11. Жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлэх;	Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлж ажилласан.	100
Хэрэгжилтийн дундаж дүн				98.18

ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА

М.НЯМСҮРЭН

ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЧИМЭГ